



БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР



НИЙЛҮҮЛЭГЧ:
ИЛДЭНГҮН ХОШУУ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.ТУНГАЛАГ



“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв”-д халдвар илрүүлэх энзимиммуны аргын оношлуур нийлүүлэх нэмэлт гэрээ.

Дугаар № 2016 он 04

Улаанбаатар хот

Нэг талаас **Цус сэлбэлт судлалын үндэсний төв** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **Илдэнгүн хошуу ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 10 сарын 03-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Донорын тоо нэмэгдэж **“Халдвар илрүүлэх энзимиммуны аргын оношлуур”**-ын нөөц багассантай холбогдуулан энэхүү нэмэлт гэрээг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34.1.4-ийн дагуу байгуулахаар шийдвэрлэв.
- 1.3 Захиалагч нь “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвд оношлуур нийлүүлэх 2016 он 04” дугаартай тендерийн **“Халдвар илрүүлэх энзимиммуны аргын оношлуурын багцын** (цаашид “бараа” гэх) нийт **17,050,000** (арван долоон сая тавин мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.4 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт **17,050,000** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

- 1.5 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 1.6 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
- 1.6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 1.6.2 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 - 1.6.3 Тендер ба үнийн хуваарь;
 - 1.6.4 Гэрээний тусгай нөхцөл;
 - 1.6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 1.6.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 1.6.7 Санхүүжилтийн хуваарь.
- Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
- 1.7 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.8 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.9 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.
- 2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.
-

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.

3.2 Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.

3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.

3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

Тав. Бусад зүйл

5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр 3 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний
Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гүнжээ
Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

Илдэнгүн хошуу ХХК-ийн
менежер Д.Эрдэмбилэг
Хаяг: БЗД, Намянжүгийн гудамж,
ХӨСҮТ, Амбулатори 401 тоот

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

Утас: 456628, 95950538, 89110538

ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ЭНЗИМИММУНЫ АРГЫН ОНОШЛУУР

№	Барааны тодорхойлолт	Олон улсын буюу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	ХДХВ-1 ба ХДХВ-2 илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	Anti-HIV ELISA	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	хайрцаг	60	143000	8580000
2	Хепатитийн С вирусийн эсрэг эсрэгбиеийг илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	Anti-HCV ELISA	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	хайрцаг	50	66000	3300000
3	Хепатитийн В вирусийн гадаргуугын эсрэгтөрөгчийг илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	HBsAg	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	хайрцаг	70	38500	2695000
4	Тэмбүүгийн спирохетийн эсрэгбие илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	Syphilis Ig M, G	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	хайрцаг	45	55000	2475000
	Нийт							17,050,000

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ-ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ЭНЗИМИММУНЫ АРГЫН ОНОШЛУУР

№	Бүтээгдэхүүний нэр	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Шаардагдаж буй хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь
1	ХДХВ-1 ба ХДХВ-2 энзим иммуны аргын оношлуур	Anti-HIV ELISA	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	60	12 сарын 10
2	Хепатитийн С вирусийн эсрэг эсрэгбиеийг илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	Anti-HCV ELISA	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	50	12 сарын 10
3	Хепатитийн В вирусийн гадаргуугын эсрэгтөрөгчийг илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	HBsAg	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	70	12 сарын 10
4	Тэмбүүгийн спирохетийн эсрэгбие илрүүлэх энзим иммуны аргын оношлуур	Syphilis Ig M, G	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	45	12 сарын 10